

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь Хүүхдийн эрхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.7 дугаар заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017оны 04 сарын 06 өдрийн А/84, А/54, А/130 дугаар тушаалын дагуу хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн /цаашид байгууллага гэх/ магадлан итгэмжлэл нь тухайн байгууллагын хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх нөөц, чадавхийг төрөөс хүлээн зөвшөөрөх, тухайн байгууллагын өрсөлдөх чадварын нотолгоо болно.

1.3. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа нь нээлттэй, ил тод, бусдын нөлөөнд үл автах, шударга байх зарчимд тулгуурлана.

1.4. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх магадлан итгэмжлэх Орон тооны бус зөвлөл /цаашид Зөвлөл гэх/-ийн хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх эсэх дүгнэлтэд үндэслэн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга магадлан итгэмжлэлийг олгоно.

1.5. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаа, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулна.

Хоёр. Зөвлөл

2.1. Зөвлөл нь Гэр бүл, хүүхдийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, холбогдох төрийн захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.3. Зөвлөлийн үйл ажиллагааг зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга удирдан зохион байгуулна.

2.4. Зөвлөлийн бүрэлдэхүүнд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, их дээд сургуулийн төлөөлөл багтана.

2.4. Зөвлөл нь дараах эрх, үүрэгтэй:

2.4.1. магадлан итгэмжлэх үйл ажиллагааг зохион байгуулах, магадлан итгэмжлэл олгох эсэх, сунгах, хүчингүй болгох шийдвэр гаргах;

2.4.2. магадлан итгэмжлүүлэхээр хүсэлт гаргасан байгууллагуудаас шаардлагатай мэдээ мэдээлэл, судалгааг гаргуулан авах;

2.4.3. шаардлагатай бол газар дээр нь очиж үйл ажиллагаатай нь танилцах, шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх;

2.4.4. магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбогдож гарсан өргөдөл, гомдлыг хянаж шийдвэрлэх;

2.4.5. магадлан итгэмжлэх үйл ажиллагааны талаар гарсан хууль тогтоомж, дүрэм, журмыг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, танилцуулах;

2.4.6. шаардлага хангаагүй байгууллагын хүсэлтийг хэлэлцэхээс татгалзаж материалыг буцаах;

2.5. Зөвлөлийн үйл ажиллагаа

2.5.1. Зөвлөл нь ээлжит ба ээлжит бус хуралтай байна.

2.5.2. Ээлжит хурал нь жилд нэг удаа хуралдах ба шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.

2.5.3. Зөвлөлийн хурлын тов, хэлэлцэх асуудлыг зөвлөлийн дарга батална.

2.5.4. Зөвлөлийн нарийн бичгийн дарга хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, холбогдох материалыг зөвлөлийн гишүүдэд ажлын 3 хоногийн өмнө цаасаар эсвэл цахим шуудангаар хүргүүлнэ.

2.5.5. Зөвлөлийн гишүүд хурлаар хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцаж, саналаа бэлдсэн байна.

2.5.6. Зөвлөлийн гишүүн хүндэтгэх шалтгаанаар хуралд ирэхгүй тохиолдолд шалтгааныг хурлаас өмнө зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргад мэдэгдэх ба хэлэлцэх асуудалтай холбоотой саналаа бичгээр өгч болно. Энэ тохиолдолд хуралд ирснээр ирцийг тооцно.

2.5.7. Зөвлөлийн гишүүдийн 75-аас дээш хувь нь буюу 7 гишүүн хуралд хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.

2.5.8. Магадлан итгэмжлэл олгох эсэх асуудлыг нээлттэй хурлаар хэлэлцэж, зөвлөлийн гишүүдийн ил санал хураалтаар шийдвэрлэнэ. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд нууцаар санал хураалт явуулна.

2.5.9. Хурлын шийдвэр нь зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно.

2.5.10. Зөвлөл нь хэлэлцсэн асуудлаар тэмдэглэл хөтөлж дарга, нарийн бичгийн дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

2.5.11. Зөвлөлийн хуралд тухайн хэлэлцэх асуудалтай холбоотойгоор холбогдох мэргэжлийн хүмүүсийг санал хэлэх эрхтэйгээр урин оролцуулж болно.

2.5.12. Зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэртэй холбогдон үүссэн гомдлыг зөвлөл дахин нэг удаа авч хэлэлцэн дүгнэлт гаргана.

2.5.13. Зөвлөлийн хурлаас гаргасан эцсийн дүгнэлттэй санал нийлэхгүй тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу холбогдох байгууллагад гомдол гаргаж болно.

Гурав. Байгууллагад тавих шаардлага, бүрдүүлэх материал

3.1. Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт нь байгууллагын хүүхэд хамгааллын үйлчилгээний чиглэл, хөрөнгө, санхүү, мэргэшсэн хүний нөөцийн чадавхиас бүрдэнэ.

3.2. Магадлан итгэмжлэлийн журамд заагдсан хүүхэд хамгааллын үйлчилгээг хоёр ба түүнээс дээш жил тогтвортой, тасралтгүй үзүүлж байгаа байгууллага гаргана.

3.3. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх байгууллага нь магадлан итгэмжлүүлэхээр дараах материалыг бүрдүүлэн гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ. Үүнд:

3.3.1. магадлан итгэмжлүүлэх тухай хүсэлтийг орон нутгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан байгууллагад гаргана;

3.3.2. байгууллагын гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар ;

3.3.3. үүсгэн байгуулагчдын болон байгууллагын танилцуулга:

- байгууллагын бүтэц, үйл ажиллагааны талаарх товч танилцуулга;
- хүүхэд хамгааллын үйлчилгээний төрөл, танилцуулга, хөтөлбөр;
- үзүүлэх үйлчилгээний хамрах хүрээ /аймаг, дүүрэг, хороо гм/;
- үзүүлэх үйлчилгээний хэрэгцээний судалгаа;
- үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай байр, тоног төхөөрөмжийн танилцуулга;
- хамгааллын үйлчилгээг үзүүлэх “үндсэн ажилтнууд”-ын анкет, хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшсэн илтгэх дипломын хуулбар, лицензийн хуулбар (нэг хүний анкет мэдээлэл 2 хуудаснаас хэтрэхгүй байх);
- магадлан итгэмжлэлд хүсэлт гаргахаас өмнө хоёр жилийн хугацаанд үзүүлсэн хүүхэд хамгааллын үйлчилгээнд нь хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо, үр дүн

3.3.4. магадлан итгэмжлэх шалгуур, үзүүлэлт, үнэлэх аргачлалын дагуу өөрийн үнэлгээний багийг томилж, үнэлгээний хураангуй тайлан бэлтгэн ирүүлэх;

3.3.5. байгууллагын сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан;

Дөрөв. Магадлан итгэмжлэл олгох, сунгах, хүчингүй болгох

4.1. Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийг 80 ба түүнээс дээш хувийг хангасан байгууллагад магадлан итгэмжлэлийг 2 жилийн хугацаагаар олгоно.

4.2. Зөвлөлийн хурлаар баталгаажсан хурлын тэмдэглэл, шийдвэрийг үндэслэн магадлан итгэмжлэлд тэнцсэн байгууллагад үйлчилгээ үзүүлэх эрхийн гэрчилгээ олгох бөгөөд дарга гарын үсэг зурж баталгаажсан өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ.

4.3. Магадлан итгэмжлэгдсэн байгууллага нь үйлчилгээ үзүүлэх эрхийн гэрчилгээний хүчинтэй хугацааг дуусахаас 90 хоногийн өмнө дахин магадлан итгэмжлүүлэх хүсэлтийг, дараах материалын хамт бүрдүүлж Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Зөвлөлд ирүүлнэ:

4.3.1. хугацаа сунгуулахыг хвссэн хүсэлт;

4.3.2. байгууллагын гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

4.3.3. магадлан итгэмжлэлийн гэрчилгээний хуулбар;

4.3.4. сунгуулах хүсэлт гаргахаас өмнөх хоёр жилийн хугацаанд үзүүлсэн хүүхэд хамгааллын үйлчилгээгээний тайлан, нотлох баримтууд (тайлан нь магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтүүдийн товъёогийн дагуу бичигдэж ажил, үйлчилгээний нотлох баримтуудыг хавсаргасан байна);

4.3.5. хүсэлт гаргасан хуулийн этгээдийг магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн үнэлгээний хуудас бүхий аймаг, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллагын албан тоот

4.4. Энэ журмын 4.3.4- т заалт, хяналт-шинжилгээ үнэлгээгээр шалгуур үзүүлэлтийг ханган үр дүнтэй сайн ажилласан, цаашид үйл ажиллагаа үргэлжлүүлэн явуулах чадавхи, бололцоотой талаарх дүгнэлт, Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар магадлан итгэмжлэлийн хугацааг дахин 1-2 хүртэлх жилийн хугацаатай сунгана.

4.5. Магадлан итгэмжлэлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:

4.5.1. зөвлөлийн хурлаас тухайн байгууллага нь цаашид үйлчилгээ үзүүлэх боломжгүй гэсэн дүгнэлт гаргасан;

4.5.2. магадлан итгэмжлэл авахаар хуурамч материал бүрдүүлсэн нь тогтоогдсон;

4.5.3 магадлан итгэмжлэл авсан байгууллага нь гэрээний хугацаанд хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлээгүй нь нотлогдсон, гэрээний заалтыг зөрчсөн;

4.5.3. Магадлан итгэмжлэлийн хугацаа нь дууссан боловч дахин сунгуулах хүсэлт гаргаагүй.

Тав. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

5.1. Магадлан итгэмжлэгдэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

5.1.1. Орон нутгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан байгууллагаас магадлан итгэмжлүүлэх байгууллагуудын хүсэлтийг хүлээн авч, ирүүлсэн материалыг зөвлөлд хүргүүлэх

5.1.2. Магадлан итгэмжлэл авсан байгууллагатай гэрээ байгуулах.

5.1.3. Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх, зарцуулалтад хяналт тавих

5.1.4. Магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудад сургалт, арга зүйн зөвлөгөө өгөх

5.1.5. Магадлан итгэмжлэгдсэн байгууллагын хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх санал гомдлыг шуурхай шийдвэрлэж дүгнэлтийг зөвлөлд хүргүүлэх

5.1.6. Магадлан итгэмжлэх байгууллагын шалгаруулалтыг жил бүрийн 11 дүгээр сард зохион байгуулж, ил тод байдлыг хангах

5.1.7. Магадлан итгэмжлэгдсэн байгууллагын бүртгэл мэдээлэл, хөдөлгөөн, хүүхэд хамгааллын үйлчилгээний хэрэгжилтийн тайлан, хяналт шинжилгээ үнэлгээний дүгнэлтийг хэлэлцэж хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад жилд нэг удаа хүргүүлнэ.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ

5.1. Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас энэ журмын 4.1-т заасан хугацаанд явцын хяналт, шинжилгээ, үнэлгээг жилд нэг удаа хийнэ.

5.2. Аймаг, дүүргийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан байгууллага нь тухайн орон нутагтаа магадлан итгэмжлэгдсэн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

5.3. Магадлан итгэмжлэгдсэн байгууллагын үйлчилгээнд үнэлэлт, дүгнэлт өгөх ажлыг үйлчлүүлэгчийн оролцоог хангасан байдлаар буюу санал асуулгын аргаар зохион байгуулж болно.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2021 оны дугаар сарын ...-ны өдрийн
..... тоот тушаалын хоёрдугаар хавсралт

**Магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн үзүүлэх хүүхэд хамгааллын
үйлчилгээний төрөл**

Түвшин	Зорилтот бүлэг	Үйлчилгээний төрөл
I. Хүүхэд хамгаалах шуурхай тусламжийн түвшний үйлчилгээ	Хүчирхийлэлд өртсөн, өртөх өндөр эрсдэлтэй хүүхэд	1.1 Нийгмийн ажлын үйлчилгээ. -эрсдлийн үнэлгээ, -нөхцөл байдлын үнэлгээ -Хүүхдийг хамгаалах аюулгүйн төлөвлөгөөг эцэг, эх асран хамгаалагчтай хамтран боловсруулах, хэрэгжүүлэх
		1.2 Холбон зуучлах үйлчилгээ -Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ -Шүүх, хуулийн байгууллагын үйлчилгээ -Түр байрлуулан асрамжлах үйлчилгээ -Сэтгэл зүйн цочрол, засал, нийгмийн ажлын үйлчилгээ
II. Хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх түвшний үйлчилгээ	Хүчирхийлэлд өртсөн ба өртөх эрсдэлтэй хүүхэд	2.1 Хүүхдийн бие махбодийн гэмтэл, сэтгэцийн өөрчлөлтийг эмчлэх, нөхөн сэргээх эрүүл мэндийн үйлчилгээ
		2.2 Сэтгэл зүйн цочрол, хямрал, гэмтлээ даван туулахад туслах сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээ
		2.3 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө, нийгмийн ажлын үйлчилгээ
		2.4 Хүүхдийн эсрэг хүчирхийллээс улбаатай хүүхдийн зан авирын өөрчлөлтөнд чиглэсэн нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө, засал, нийгмийн ажлын үйлчилгээ
		2.5 Хүчирхийлэлд өртсөн, гэмт хэргийн золиос болсон хүүхдэд үзүүлэх өмгөөлөл, хүүхэд хамгааллын үйлчилгээ
		2.6 Хохирогч хүүхдийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээ
		2.7 Хүчирхийлэл өртсөн ба өртөх эрсдэлтэй хүүхдэд зориулсан асрамжийн хувилбарт үйлчилгээ
	Хүчирхийлэлд өртсөн ба өртөх эрсдэлтэй хүүхдийн гэр бүлийн гишүүд	2.8 Түр хамгаалах байр болон халамж, асрамжийн төвөөс хүүхдийг эргэн нэгтгэх үйлчилгээ
		2.9 Эцэг эхчүүдэд зориулсан хүүхдийн хөгжил, хүмүүжлийн эерэг аргуудын тухай зөвлөгөө, сургалт
		2.10 Гэр бүлийн зөрчил, хямрал, хүчирхийллээс сэргийлэх, гэр бүлийн хамгаалах хүчин зүйлсийг бэхжүүлэхэд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ
		2.11 Гэр бүлийн эерэг, эрүүл харилцаа, үнэт зүйлсийг бий болгох, гэр бүлд туслах тогтолцоог өргөжүүлэх зэрэг гэр бүлийг дэмжих нийгмийн ажлын үйлчилгээ
		2.12 Эцэг эх – хүүхдийн харилцаа холбоог бэхжүүлэх гэр бүлийн зөвлөгөө засал, сургалт,
		2.13 Архи болон мансууруулах бодисоос хамааралтай эцэг эх, асран хамгаалагчтай ажиллах тусгай хөтөлбөр ба үйлчилгээ

		2.14 Бэлгийн болон бусад хүчирхийлэлд өртөж байсан түүхтэй эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан зөвлөгөө засал, нөхөн сэргээх үйлчилгээ
	Асран халамжлагчид	2.15 Асралт эцэг эх болон хүүхэд асрамжилсан, үрчлэн авсан асран халамжлагчид зориулсан хөтөлбөр, үйлчилгээ
III. Урьдчилан сэргийлэх түвшний үйлчилгээ	Цэцэрлэгийн багш, ажилтан, эцэг эх	3.1 Хүүхдийн эсрэг хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр сургуулийн өмнөх насны хүүхэд, тэдний эцэг эх, багш удирдах ажилтнуудад зориулсан тусгай хөтөлбөр
	Багш сурагчид	3.2 Сургууль болон түүний орчинд хүүхдийн эсрэг хүчирхийллээс хамгаалах ба сэргийлэхэд чиглэсэн тусгай хөтөлбөр
	Өсвөр үеийнхэн, сургуулийн сурагчид	3.3 Үе тэнгийнхний дарамт, хүчирхийллээс сэргийлэх хөтөлбөр
	Эцэг эх, асран хамгаалагчид	3.4 Хүүхэдтэй зүй бус харьцах явдлаас сэргийлэх, хүмүүжлийн эерэг арга түгээх хөтөлбөр
	Олон нийт	3.5 Хүүхэдтэй зүй бус харьцах явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх хэвлэл мэдээллийн аян
	Олон нийт	3.6 Хүүхэдтэй зүй бус харьцах явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр түншлэлийг хөгжүүлэх хөтөлбөр

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2021 оны дугаар сарын ...-ны өдрийн
..... тоот тушаалын гуравдугаар хавсралт

**Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх
хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт**

№	Шалгуур үзүүлэлт	Авбал зохих дээд оноо	Авсан оноо	Тайлбар
БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХИ				
1	Байгууллагын тухай ерөнхий мэдээлэл	1.1. Байгууллагын дүрэм	1	
		1.2. Байгууллагын дотоод журам	1	
		1.3. Байгууллагын стратеги төлөвлөгөө	1	
		1.4. Жилийн ажлын төлөвлөгөө	1	
		1.5. Үйл ажиллагааны жилийн тайлан	1	
2	Байгууллагын хүүхэд хамгааллын дүрэм	2.1. Бүх ажилтандаа хүүхэд хамгааллын дүрмийг мөрдөж ажиллах заавар өгч, гарын үсэг зуруулан хөдөлмөрийн гэрээнд хавсаргасан байдал	1	
		2.2. Хүүхэд хамгааллын дүрмийн хэрэгжилтийг хангах чиглэлээр гаргасан шийдвэр	2	
3	Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, багийн бүрэлдэхүүн, тэдний мэргэшсэн байдал	3.1. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх үндсэн ба гэрээт ажилтны тушаал, хөдөлмөрийн гэрээний хуулбар	1	
		3.2. Байгууллагын үндсэн ажилтны 30 хувь нь мэргэжлийн нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшсэнг илтгэх диплом, лиценц, мэргэжил дээшлүүлсэн гэрчилгээний хуулбар	2	
		3.3. Хохирогчийг түр хамгаалах байр ажиллуулах ¹ , хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх ² тохиолдолд стандартын хүний нөөцөд тавих шаардлагыг хангасан байдал	2	
		3.4. Ажилтнуудаа мэргэжлийн удирдлагаар хангадаг эсэх	2	

¹ МУ-ын Стандарт (6040:2019). Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага 11.1-11.12 заалтууд

² МУ-ын Стандарт (MNS 5852). Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага, 11.1-11.11 заалтууд

4	Эрх бүхий байгууллагаас баталсан хүүхэд хамгааллын үйлчилгээний журам, стандарт, маягт ашиглалт, бүртгэл	4.1. Хүүхэд хамгааллын холбогдох стандарт, журам, маягтын хөтлөлт, хяналт	2		
		4.2. Үйлчлүүлэгчийн хувийн хэргийн хөтлөлт, хадгалалт	2		
		4.3. Хамгааллын үйлчилгээний бүртгэл, тайлан	2		
5	Хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой тухайн байгууллагад ирсэн гомдол, саналыг шийдвэрлэсэн байдал	5. Үйлчлүүлэгчийн гомдол саналын бүртгэл, авсан арга хэмжээний тайлан.	1		
6	Дэд хэсгийн оноо		22		
ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАДАВХИ					
7	Байгууллагын Хүүхдэд чиглэсэн нэгдсэн хөтөлбөр	6.1. Хүүхдийн хөгжил хамгааллын үйлчилгээний хөтөлбөртэй эсэх	2		
		6.2. Үйлчилгээний болон сургалтын материал, хэрэглэгдэхүүн, тараах материал	2		
		6.3. Үйлчилгээний үр дүн, үйлчлүүлэгчид гарсан ахиц өөрчлөлтийг үнэлэх арга	2		
		6.4. Үнэлэх, тайлагнах заавар	2		
8	Хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн түвшний үйлчилгээ	7.1. Хүүхэд, түүний гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээг холбогдох журмын ³ дагуу хийх	2		
		7.2. Хүүхдийн аюулгүй байдлын төлөвлөгөөтэй эсэх	2		
		7.3. Холбон зуучлах журмыг ⁴ мөрдөж, эргэн мэдээлэх хуудас бөглөдөг эсэх	2		
		7.4. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх тохиолдолд Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээний MNS 6040-2019 стандартын 12-оос 15-р заалтуудыг ⁵ хангасан байдал	2		
		8.1. кейс менежментийн хамтарсан төлөвлөгөө, тайлан	2		

³ ХНХ-ын сайд, ХЗДХ-ийн сайдын 2017 оны А1201/А178 тоот хамтарсан тушаалаар баталсан Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам, Хүүхэд хамгааллын үйлчилгээний багш маягууд

⁴ ХНХ-ын сайдын 2017 оны А/73 тоот тушаалаар батлагдсан Холбон зуучлах журам, түүний хавсралтууд

⁵ СХЗГ (2019). Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага нэртэй стандарт (MNS: 6040:2019)-ын 12-аас 15-р зүйлүүдэд заасан түр хамгаалан байрлуулах, түр хамгаалах байранд үзүүлэх үйлчилгээнд тавих шаардлага, нууцлал хангах, хориглох зүйл зэрэг зүйл, заалтууд хамаарна,

9	Хүүхэд хамгааллын нөхөн сэргээх түвшний үйлчилгээ	8.2. Хамтарсан багийн холбогдох журмын ⁶ дагуу үйлчилгээг төлөвлөх	2		
		8.3. Хүүхдийг гэр бүлийн орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх тохиолдолд холбогдох стандарт, дүрэм зааврыг мөрдөн ажиллах	2		
		8.4. Хүүхдийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх тохиолдолд Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээний MNS 6040-2019 стандартын 12-оос 15-р заалтуудыг ⁷ хангах	2		
10	Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх түвшний үйлчилгээ	9.1. Хүүхэд хамгааллын нөлөөллийн ажлын төлөвлөгөөтэй эсэх	2		
		9.2. Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөртэй эсэх	2		
		9.3. Урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн гарын авлага, бусад сурталчилгааны материал	2		
11	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ авсан үйлчлүүлэгчид гарсан ахиц өөрчлөлт, үр дүн	10.1. Хүүхэд хамгааллын үйлчилгээний үр дүн тооцдог эсэх /Ахиц өөрчлөлтийн тэмдэглэл/	2		
		10.1.1. Үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо	2		
		10.1.2. Үйлчлүүлэгчийн мэдээллийн бүртгэл	2		
		10.1.3. Үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээ	2		
		10.1.4. Хүүхэд, түүний гэр бүлд эерэг өөрчлөлт гарсан тохиолдлын тоо	3		
		10.2 Хүүхдийн хувийн хэргийн бүрдэл, архивласан байдал	3		
12	Хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ	11.1.Сэтгэл ханамжийн судалгаа	3		
		11.2.Судалгааны зөвлөмжийн дагуу үйлчилгээ, хөтөлбөрийн сайжруулалт хийдэг эсэх	3		
13	Дэд хэсгийн оноо		50		

⁶ ХНХ-ын сайд, ХЗДХ-ийн сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан 2017 -оны А/173, А/259, А/3801 тоот Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам, дагалдах маягтууд

⁷ СХЗГ (2017). МУ-ын Стандарт Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагын (6040:2019). 12-аас 15-р зүйлүүдэд заасан түр хамгаалан байрлуулах, түр хамгаалах байранд үзүүлэх үйлчилгээнд тавих шаардлага, нууцлал хангах, хориглох зүйл зэрэг зүйл, заалтууд хамаарна,

ХӨРӨНГӨ, САНХҮҮГИЙН ЧАДАВХИ

12	Мэргэжлийн оношлогоо, стандарт тест, тоног төхөөрөмжийн мэдээлэл	12.1 Хүүхэд хамгааллын үйлчилгээнд ашиглаж буй тоног төхөөрөмжийн хүчин чадал, ашиглалт чанарын шаардлага хангасан эсэх	3		
		12.2 Хүүхэд хамгааллын үйлчилгээнд ашиглаж буй оношлогоо, тестийн баталгаат чанар	3		
		Хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, ганцаарчилсан уулзалт хийх өрөө танхимтай эсэх	3		
13	Санхүүгийн эх үүсвэр	12.3 Хоёроос цөөнгүй санхүүжилтийн эх үүсвэртэй эсэх	4		
		12.4 Санхүүгийн тайлан балансаа ил тод, нээлттэй тайлагнадаг эсэх	5		
		12.5 Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв	5		
		12.6 Хандив тусламжийн бүртгэл, зарлага	5		
	Дэд хэсгийн оноо		28		
	НИЙТ ОНОО		100		

---с00о---

**Төвлөрсөн халамж, асрамжийн үйлчилгээ үзүүлэх
хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт**

№	Шалгуур үзүүлэлт	Авбал зохих дээд оноо	Авсан оноо	Тайлбар	
1.	Ерөнхий мэдээлэл	1.1 Үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл	2		
		1.2 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ	2		
		1.3.Байгууллагын дүрэм	2		
		1.4.Байгууллагын дотоод журам	2		
		1.5 Ажилтнуудын ёс зүйн дүрэм	1		
		1.6 Байгууллагын стратеги төлөвлөгөө	2		
		1.7 Жилийн ажлын төлөвлөгөө	2		
		1.8 Үйл ажиллагааны жилийн тайлан	2		
		1.9 Харьяалах нутаг дэвсгэр дэх Засаг дарга, гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагатай хийсэн гэрээ	2		
		1.10 Байр, зай талбайн хэмжээ, орчин эрүүл ахуйн стандарт ⁹ ын шаардлага хангасан эсэх	2		
		1.11 Гэр бүлийн орчин бүрдүүлэлт /Нэг өрөөнд 5 хүртэл хүүхэд/	2		
		1.12.Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний стандартын шаардлага хангасан эсэх	2		
			1.12 Жилийн ажлын төлөвлөгөө тайлан	2	
Дэд хэсгийн оноо		25			
2.	Хүний нөөц	2.1 Мэргэжлийн удирдлагатай эсэх /Удирдах зөвлөлийн гишүүдийн танилцуулга/	5		
		2.2 Байгууллагын хүний нөөцийн бүтэц бүрэлдэхүүний зураглал	5		
		2.3 Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавигдах нийтлэг	5		

		шаардлага MNS 5852:2017 стандартын шаардлагын дагуу хүний нөөцтэй эсэх			
		2.4 Ажилтнуудад зориулсан хүүхдийн эрх, хамгаалал, тэдний сэтгэл зүй, нас хөгжлийн онцлогийн талаар болон бусад сургалтын төлөвлөгөөтэй эсэх	5		
		2.5 Эрүүл мэндийн шуурхай тусламж үйлчилгээний сургалтад хамрагдсан эсэх	5		
		Дэд хэсгийн оноо	25		
3.	Хүүхдэд үзүүлэх үйлчилгээ	3.1 Хүүхэд хамгааллын бодлогод ажилтнууд гарын үсэг зурж хөдөлмөрийн гэрээнд хавсаргасан эсэх	2		
		3.2 Хүүхдийн аюулгүй байдлын төлөвлөгөөтэй эсэх	2		
		3.3 Хүүхдийн бие даан амьдрахад чиглэсэн хөтөлбөр нь нас хөгжлийн онцлогт нийцсэн эсэх	3		
		3.4 Хүүхдийн асуудлыг мэдээлэх журамтай эсэх	2		
		3.5 Хүүхдийн хөгжлийн төлөвлөгөөтэй эсэх	2		
		3.6 Хүүхдийн хөгжил хамгаалал, бие даан амьдрах тусгай хөтөлбөртэй эсэх	2		
		3.7 Хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийн үнэлгээ хийгдсэн эсэх	2		
		3.8 Хүүхдэд гарсан ахиц өөрчлөлтийг үнэлгээтэй эсэх	2		
		3.9 Хүүхдийн ахиц өөрчлөлтийн тэмдэглэлийн дагуу хөгжлийн хөтөлбөр болосруулсан эсэх	2		
		3.10 Хүүхдийн хувийн хэрэг буюу кейс файлын бүрдэл товчоон дагуу бүрдүүлсэн эсэх	2		
		3.11 Хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээний картыг хувийн хэрэгт хавсаргасан эсэх	2		
		3.12 Гэр бүлд нь эргэн нэгтгэсэн болон чөлөөгөөр гарсан хүүхдийн бүртгэл судалгаа	2		
		Дэд хэсгийн оноо	25		
4		4.1 Хоёроос цөөнгүй санхүүжилтийн эх үүсвэртэй эсэх	5		

Санхүүгийн үүсвэр	эх	4.2 Санхүүгийн тайлан балансаа ил тод, нээлттэй тайлагнадаг эсэх	5		
		4.3Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв, түүний тайлагналт	5		
		4.4Хүүхэд хамгааллын үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт	5		
		4.5Цар тахлын үед яаралтай авч хэрэгжүүлэх санхүүгийн нөөц төсөв төлөвлөгөө	5		
Дэд хэсгийн оноо			25		
НИЙТ ОНОО			100		

---с00о---

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2021 оны дугаар сарын ...-ны өдрийн
тоот тушаалын тавдугаар хавсралт

**Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан
итгэмжлэх шалгуур үзүүлэлт**

№	Шалгуур үзүүлэлт	Авбал зохих дээд оноо	Авсан оноо	Тайлбар
БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХ				
1	Монгол Улсад бүртгэлтэй -хуулиар ногдуулсан үүргээ зохих ёсоор биелүүлдэг хуулийн этгээд байх	1.1 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ	1	
		1.2 Тухайн байгууллагын талаарх бусад холбоо хамаарал бүхий хөндлөнгийн мэргэжилтэн, байгууллага, мэргэжлийн холбоодын тодорхойлолт /дор хаяж 2 тодорхойлолт/	2	
		1.3 Шүүхийн шийдвэрээр төлбөргүй эсэх лавлагаа	1	
2	Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн зэрэг нийгмийн эмзэг, эрсдэлт бүлгийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр 2-оос доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа эрхэлсэн байх	2.1 Удирдах зөвлөлийн гишүүдийн болон байгууллагын танилцуулга	1	
		2.2 Байгууллагын бүтэц, үйл ажиллагааны талаарх товч танилцуулга	1	
		2.3 Байгууллагын эрхэм зорилго, алсын харааг тодорхойлсон бодлого стратегийн баримт бичиг	1	
		2.4 Байгууллагын үйл ажиллагааны сүүлийн 2 жилийн тайлан	2	
		2.5 Сүүлийн нэг жилд үйлчлүүлсэн үйлчлүүлэгчийн тоо, ерөнхий статистик мэдээлэл	2	
		2.6 Өмнө нь магадлан итгэмжлэлд хамрагдаж тухайн үйлчилгээг үзүүлж байсан бол үйлчилгээ үзүүлэх хүрээнд хөтөлсөн баримт бичгүүд / Өмнө нь үзүүлж байгаагүй бол автоматаар 2 оноогоо авах/	2*	
3	Хуулийн этгээдийн удирдах эрх бүхий байгууллагаас магадлан	3.1 Байгууллагын дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар	1	
		3.2 Байгууллагын дүрмийн дагуу эрх бүхий этгээдийн шийдвэр	1	

	итгэмжлэлд хамрагдах шийдвэр гарсан байх	3.3 Удирдах зөвлөлийн сүүлийн 1 жилийн хурлын тэмдэглэл	2		
4	Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийн өөрийн үнэлгээний аргачлалын дагуу үнэлж 100 хувь шалгуурыг хангасан байх	4.1 Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлалын дагуу өөрийн үнэлгээний тайлан	3		
		4.1 Хяналт үнэлгээнд оролцсон, удирдан зохион байгуулсан албан тушаалтан, ажилтнуудын нэр гарын үсэг бүхий жагсаалт	2		
5	Байгууллагын эрсдэлийн төлөвлөгөөтэй, төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж үнэлдэг байх	5.1 Галын аюулын үед авах арга хэмжээний төлөвлөгөө	2		
		5.2 Гамшиг ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө	2		
		5.3 Бүх нийтийн халдварт өвчин буюу цар тахлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө	2		
		5.4 Байгууллагын үйл ажиллагаа нь үйлчлүүлэгчдэд гэм хор учруулж болзошгүй эрсдэлийг тодорхойлсон үнэлгээний тайлан	3		
		5.5 Даатгалд хамрагдсан байдал /Үүнд: Байгууллагын үл хөдлөх эд хөрөнгийн даатгал, Байгууллагын тээврийн хэрэгслийн даатгал/	2		
6	Байгууллага санхүүгийн хувьд чадавхжсан байх	6.1 Байгууллагын өмнөх 2 жилийн санхүү, татвар, нийгмийн даатгалын тайлан	3		
		6.2 Санхүү, худалдан авалтын бодлого, журам	3		
		6.3 Үйлчилгээнд зарцуулах төсвийн төлөвлөгөө	3		
		6.4 Цар тахлын үед яаралтай авч хэрэгжүүлэх санхүүгийн нөөц төсөв төлөвлөгөө	3		
		6.5 Нэгээс доошгүй жил үйл ажиллагаа явуулахад шаардагдах санхүүжилт, хөрөнгийн баталгаа	3		
7	Үйлчилгээ үзүүлэх шаардлага хангасан байртай байх	7.1 Зориулалт бүхий өөрийн өмчийн байртай бол үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, хэрэв түрээсийн байртай бол түрээсийн гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар	1		
		7.2 Байрны байршил, хэмжээ, өрөө тасалгаа, хүчин чадал, эрүүл ахуйн шаардлага	1		

		нөхцөлийг тодорхойлсон танилцуулга			
Дэд хэсгийн оноо			50		
ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХ					
8	Үйлчилгээ үзүүлэх багийн бүтэц, бүрэлдэхүүн, чиг үүргийг нарийвчлан тодорхойлсон байх	8.1 Байгууллагын үйлчилгээ үзүүлэх багийн бүтэц бүрэлдэхүүний зураглал	10		
		8.2 Ажилтнуудын ажилд томилсон тушаал, хөдөлмөрийн гэрээний хамт	2		
		8.3 Ажлын байрны тодорхойлолт	2		
		8.4 Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх талаарх лавлагаа бүрдүүлсэн ажилтнуудын бүртгэл	2		
		8.5 Байгууллагын дотоод журам	2		
9	Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах бодлого, төлөвлөгөөтэй байх	9.1 Харуул хамгаалалт, ажлын байрны орчин, тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагааны журам	2		
		9.2 Цахилгаан, сантехник, шугам сүлжээний засвар үйлчилгээ, хог хаягдлын үйлчилгээ авах талаар тусгайлсан нууцлалын гэрээ	2		
		9.3 Аюулгүйн дохиолол, гадаад, дотоод орчныг хянах хяналтын сүлжээтэй, хамгааллын үйл ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагатай байгуулсан гэрээ	2		
		9.4 Цахим орчинд хувь хүн, байгууллагын нууцлалыг хамгаалах журам	2		
10	Мэргэжлийн чадавхжсан хүний нөөцтэй байх	10.1 Ажилтан бүрийн товч намтар, мэргэжил, мэргэшлийн зэргийг тодорхойлсон баримт бичгийн хуулбар	2		
		10.2 Ажилтнуудыг ажлын байран дээр сургаж дадлагажуулах, ур чадварыг нэмэгдүүлэх, урамшуулах байгууллагын төлөвлөгөө, хөтөлбөр	2		
		10.3 Мэргэжлийн чадавх нөөцөөс шалтгаалан гэрээгээр ажилтан авах төлөвлөгөө, гэрээт ажилтны товч намтар, мэргэжил, мэргэшлийн зэргийг	2		

		тодорхойлсон баримт бичгийн хуулбар			
11	Байгууллагын үндсэн, гэрээт, сайн дурын ажилтнууд хүлээн зөвшөөрсөн ёс зүйтэй байх	11.1 Байгууллагын хүний нөөцийн бодлого	2		
		11.2 Байгууллагын хүүхэд хамгааллын бодлого	3		
		11.3 Байгууллагын хүүхэд хамгаалын бодлоготой танилцаж, түүнийг хүлээн зөвшөөрсөн ажилтнуудын гарын үсэг бүхий баримт бичиг/гэрээ	3		
		11.4 Үйлчлүүлэгчийн хувийн нууцлал хадгалах, үйлчлүүлэгчтэй харилцах ёс зүйн дүрэм, түүнийг хүлээн зөвшөөрсөн ажилтнуудын гарын үсэг бүхий баримт бичиг/гэрээ	3		
		11.5Авилгал, ажлын байрны бэлгийн дарамтаас сэргийлэх байгууллагын бодлого	3		
		11.6Жендерт суурилсан хүчирхийллийн хохирогчтой ажиллахад баримтлах ёс зүйн дүрэм	10		
		11.7Хөгжлийн бэрхшээлийн талаар баримтлах байгууллагын бодлого	10		
		11.8Байгууллагын дүрэм, ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд хариу арга хэмжээ авах журам	10		
		11.9Хууль, тогтоомж, бодлого журмын талаарх ажилтнуудын ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт нөлөөллийн ажлын төлөвлөгөө, хөтөлбөр	50		
Дэд хэсгийн оноо			50		
Нийт хэсгийн оноо					

Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх заавар

1. Танилцуулга

- 1.1. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журмын дагуу магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргаж байгаа байгууллага, хүсэлт гаргасан байгууллагын харъяалагдах аймаг, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага, гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон төрийн захиргааны төв байгууллагын оролцогч талууд нэгдсэн арга аргачлалаар өөрийн үнэлгээний тайлан, нотлох баримт, хяналт, үнэлгээ хийхэд зориулан энэхүү зааврыг боловсруулан гаргав.
- 1.2. Магадлан итгэмжлэх үнэлгээний оролцогч талууд ХНХ-ын сайдын 2021 оны тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам”-ын дагуу магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан байгууллагын бүрдүүлсэн материалыг тус журмын холбогдох хавсралтаар баталсан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлнэ.
- 1.3. Магадлан итгэмжлэлийн үнэлгээний оролцогч талууд гэдэгт 1-рт хүсэлт гаргаж буй байгууллагын өөрийн үнэлгээний баг; 2-рт аймаг, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага; 3-рт гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх зөвлөлийн гишүүд хамаарна.
- 1.4. Энэ журмын хоёрдугаар хавсралтаар баталсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт” -ийг тусдаа хараат бусаар үнэлэхдээ тухайн шалгуур үзүүлэлтүүд бүхий ижил хүснэгтийг ашиглана.
- 1.5. Энэ журмын нэгдүгээр хавсралтаар баталсан “Магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээний түвшин, зорилтот бүлэг, үйлчилгээний төрөл”—ийн хүрээнд үйлчилгээ үзүүлэхээр магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан байгууллагын өөрийн үнэлгээний тайлан, нотлох баримтуудад холбогдох гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын оролцогч талууд шаардлагатай тохиолдолд газар дээр нь очиж танилцан, үнэлгээ дүгнэлт өгнө.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2021 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
..... тоот тушаалын долдугаар хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГАД ОЛГОХ ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР

Магадлан итгэмжлэгдсэн байгууллагад олгох үйлчилгээ үзүүлэх эрхийн гэрчилгээ нь дараах загвартай байна:

1. Гэрчилгээ нь 20х30 см хэмжээтэй, цайвар шаргал өнгийн соёмбо бүхий дэвсгэртэй, захаараа өлзий хээн хүрээтэй байна.
2. Гэрчилгээний дээд хэсэгт гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын логог байрлуулж, түүний доод хэсэгт “ГЭРЧИЛГЭЭ” гэж бичсэн байна.
3. Гэрчилгээ нь дугаартай байна. Дугаарыг нэгж, аравт, зуутын оронтой тоогоор тэмдэглэх ба батламж олгосон огноог бичнэ.
4. Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

/Магадлан итгэмжлэгдсэн байгууллагын нэр/
.....
.....

Нь

**хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ
үзүүлэх шалгуур үзүүлэлтийг хангасан тул**

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭВ.

202 ... оны ... сарын ... өдөр хүртэл хүчинтэй.

ДАРГА...../ /
/гарын үсэг/ / овог нэр/

202

/магадлан итгэмжлэлийн эхлэх он, сар, өдөр/

Сунгалтын хугацаа: оны дугаар сарын -ны өдөр

ДАРГА
/гарын үсэг/ / овог нэр/